

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Дугаар

Улаанбаатар
хот

Аргачлал батлах тухай

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /шинэчилсэн/-ийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ НЬ:**

- 1.Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх аргачлалыг хавсралт ёсоор баталсугай.
- 2.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяад, тогтоолыг хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар (Л.Мөнхзул)-т тус тус үүрэг болгосугай.
- 3.Энэхүү тогтоолыг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

ТЭТГЭВРИЙН ХЭМЖЭЭГ НЭМЭГДҮҮЛЭХ АРГАЧЛАЛ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү аргачлалын зорилго нь Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу тэтгэвэр тогтоолгох авч буй тэтгэвэр авагчийн тэтгэврийн хэмжээг өмнөх оны инфляцын жилийн дундаж түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.

Хоёр.Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх

2.1.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д заасны дагуу тэтгэврийн хэмжээг өмнөх оны инфляцын жилийн дундаж түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэхдээ жил бүрийн Монгол улсын нэгдсэн төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөл, төсөөллийг баталсан хууль /цаашид “хууль” гэх/-иар тогтоосон “хэрэглээний үнийн өсөлтийн түвшин” үзүүлэлтийг үндэслэн дараах томъёог хэрэглэнэ. Үүнд:

2.1.1.Тэтгэвэр тогтоолгон авч байгаа иргэдийн тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэхэд:

$$T_1 = T_0 + T_0 * (XY\Theta T_1 + (I_0 - XY\Theta T_0))$$

T_1 -нэмэгдсэний дараах тэтгэврийн хэмжээ;

T_0 -авч буй тэтгэврийн хэмжээ;

$XY\Theta T_1$ -тэтгэвэр нэмэгдүүлэх жилийн холбогдох хуульд заасан хэрэглээний үнийн өсөлтийн төсөөлөл;

I_0 -Үндэсний статистикийн хорооноос зарласан өмнөх оны инфляцын жилийн дундаж түвшин;

$XY\Theta T_0$ -холбогдох хуульд заасан өмнөх оны хэрэглээний үнийн өсөлтийн төсөөлөл;

2.1.2.Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх томъёоны $(I_0 - XY\Theta T_0)$ үзүүлэлтийг 2026 оноос эхлэн тооцно.

2.2.Төсвийн жилийн 1 дүгээр улиралд Үндэсний Статистикийн хорооноос зарласан өмнөх оны бодит инфляцын жилийн дундаж түвшин болон хуулиар

тогтоосон хэрэглээний үнийн өсөлтийн түвшин зөрүүтэй тохиолдолд зөрүүгийн хэмжээг үндэслэн дараа жилийн тэтгэвэр нэмэгдүүлэхэд шаардлагатай төсвийг тооцох, мөн тэтгэврийг нэмэгдүүлэхэд харгалзан үзнэ.

2.3.Энэхүү аргачлалын 2.1-д заасны дагуу тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлсэн дүн дээр Зарим иргэний тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай хуулийн дагуу олгосон нэмэгдэл (50,000 төгрөг)-ийг нэмнэ.

2.4.Тэтгэвэр бодох цалинд хэрэглэх итгэлцүүрээр тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх арга хэмжээ энэ аргачлалд хамаарахгүй.

Гурав.Хяналт, хариуцлага

3.1.Энэ тогтоолын хэрэгжилтэд нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагын холбогдох чиг үүрэг бүхий нэгж, нийгмийн даатгалын болон нийгмийн хамгааллын хяналтын улсын байцаагч хяналт тавина.

3.2.Энэхүү журмыг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---oO---